



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²¹ оны 09⁰⁹ дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 108/1575

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БАДЕЛХАН ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд:

ҮҮ ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нараас санаачлан боловсруулсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нараас санаачлан боловсруулсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хуулийн төсөл санаачлагчдад уламжлахаар тогтов.

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар нэмж тусгах 7.1.3-т "ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах..." гэж аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарахаар тусгажээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтад орон нутгийн чиг үүрэгт хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамжийн асуудал нь хамаарахаар заасныг анхаарч орон нутагт хамаарах чиг үүргийн хүрээнд холбогдох зохицуулалтыг тусгах;

Түүнчлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх, мөн зүйлийн 6 дахь заалтаар нэмж тусгах 10.1.13-т "...орон нутгийн Захиргаанд..." гэж тусгасныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан агуулга, нэр томъёотой уялдуулах;

Хуулийн төсөлтэй холбогдуулан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөх хугацаатай нийцүүлэн боловсруулах;

2. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар өөрчлөн найруулах 9.10, мөн зүйлийн 10 дахь заалтаар өөрчлөн найруулах 10.1.1, мөн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтад Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын

зохицуулалтыг тусгахдаа Усны тухай хуулийн 16¹ дүгээр зүйлд заасан Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй уялдуулах;

3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн тайлангийн хамт санал дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлэхээр заасан тул тус хуульд заасан шаардлагыг ханган, хуулийн төслийн холбогдох судалгааг хийх;

4. Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын хавсралтын 112-т Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2021 оны IV улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг шинэчилсэн найруулгад нэгтгэн тусгах боломжтой байгааг анхаарах;

5. Хуулийн төслийн үг үсэг, агуулгын болон хууль зүйн техник, найруулга зүйн алдаатай байгааг анхаарч, хуулийн төслийн бичвэр, найруулгыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг ханган боловсруулах нь зүйтэй." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР